



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatural@parliament.mn
http://www.parliament.mn

2021 08-13 № 80

Асуулт тавих тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах зорилтыг дэвшүүлсэн. Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлаар газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор "Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай" хуулийг 2021 оны нэгдүгээр сарын 29-ний өдөр баталсан.

Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.2-т заасны дагуу болон "Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай" хуулийг боловсруулан ажилласан Ажлын хэсгийн ахлагчийн хувиар Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1. "Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай" хуулийн хэрэгжилтийн явцын талаар;
2. "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр"-ийн бүтээн байгуулалтын төлөвлөгөөт ажлын явцын талаар;
3. Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 32 дугаар Захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн танилцуулга, мэдээлэл зэрэг болно.

Энэхүү асуултын хариуг Улсын Их Хурлын тухай хуульд заасны дагуу Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд танилцуулахыг Танаас хүсье.

Хувийг: "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-д.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Г.ТЭМҮҮЛЭН

